



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 07 өдөр

Дугаар A/129

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд сумын хэсгийн төлөөлөгч, аймгийн Цагдаагийн газрын даргатай байгуулсан гэрээний биелэлтийг хангах зорилгоор хэсгийн төлөөлөгчийг малжуулах зардалд 4 950 000 (дөрвөн сая есөн зуун тавин мянган) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардлыг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Нандин-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Намжилноров)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Н.ХАТАНБААТАР